

Төгсөгчийн сэтгэгдэл

Н.Маржангул

- Цүкүбагийн Их Сургууль
- Амьд байгаль, хүрээлэн буй орчин судлалын тэнхим
- Магистр: JDS 2012-2014
- Доктор: JDS 2017-2020



Миний хувьд “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр”-ийн хүрээнд 2 удаа тэтгэлэг авсан их азтай нэгэн. Эхнийх нь 2012-2014 онд Цүкүбагийн их сургуульд суралцан магистрын зэрэг авсан бол, 2017-2020 онд докторын зэрэг амжилттай хамгаалсан.

Цүкүбагийн их сургуульд Хүрээлэн буй орчны судалгааны хөтөлбөрт хамрагдсанаар хүрээлэн буй орчны бохирдол үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, хамгаалал гэх мэт асуудлуудыг олон талаас нь авч үзэн, онол практикийн мэдлэгээ дээшлүүлэх боломжоор хангагддаг. Оюутнуудаа ирээдүйд хүрээлэн буй орчны тулгамдсан асуудлуудын шийдвэрлэгч нэгэн байна гэдэг өнцгөөс харан өөрийн санал бодлоо зөв цэгцтэй илэрхийлэх арга барилд сургах тал дээр түлхүү ажилладаг.


Гадаад оронд суралцахад шинэ орчинд дасан зохицохоос эхлүүлээд олон янзын асуудлууд үүсдэг билээ. Тэгвэл JDS хөтөлбөр нь ямар ч нөхцөл байдалд чамайг орхилгүй үргэлж хамт байна гэдэгт эргэлзэх хэрэггүй юм. JDS хөтөлбөр маань энэ мэтчилэн маш олон давуу талтай байдаг учир залуус та бүхэн уг хөтөлбөрт хамрагдах боломжийг алдаж болохгүй шүү. Нэмээд хэлэхэд, Цүкүба хот нь оюутнуудад амьдарч суралцахад хамгийн тааламжтай орчинтой.

Шинээр элсэн суралцах болсон залуустаа цаг хугацаа харвасан сум мэт шунгинаад өнгөрдөг тул, шантрах амаргүй даваанууд гарч ирэх хэдий ч өмнөө тавьсан зорилгоо бодон урагшилж, шинэ найз нөхдийн хүрээг тэлэн, олон сайхан дурсамж бүтээгээрэй хэмээн хүсэн ерөөе.

Хөтөлбөрийн тойм

“Хүний Нөөцийг Хөгжүүлэх JDS Тэтгэлэгт Хөтөлбөр” нь Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй урт хугацааны хөтөлбөр юм Тус хөтөлбөрийн зорилго нь төрийн албан хаагчдыг Япон улсын их дээд сургуулиудын магистрантурт (2жил)/Докторантурт (3жил) суралцуулах замаар Монгол улсын хүний нөөцийн хөгжлийг дэмжиж, Монгол Японы найрамдалт харилцааг бэхжүүлэхэд оршино. Докторын хөтөлбөр нь ирээдүйд эх орондоо удирдах албан тушаал хаших төрийн 1 албан хаагчийг сонгон шалгаруулж 2020-2021 оны Японы хичээлийн жилд суралцуулахаар 2020 оны элсэлтээ зарлаж байна. (2021 оны 9-10 сард сургуульдаа элсэн.)

Мэдээлэл авах хаяг



Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Төв (JICE)

JICE JDS Төслийн Монгол дахь Оффис


Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж, Монгол-Япон Төвийн байр, 201 тоот

Утас: 976-11-327052, 976-11-326815

Цахим шуудан: jds.mongolia@jice.org

Facebook хаяг: @JDSMongolia

Ажлын цаг: Даваа-Баасан 9:00 - 12:30, 14:00 - 17:30



Япон улсын докторантурт суралцах тэтгэлэгт хөтөлбөр

Япон Улсын Засгийн Газрын Буцалтгүй
Тусламж “Хүний Нөөцийг Хөгжүүлэх
(JDS) Тэтгэлэгт Хөтөлбөр”
Монгол Улс, 2020



Суралцах чиглэл

JDS оюутан нь Монгол орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болон хөгжлийн асуудлуудыг шийдэхэд чиглэгдсэн дараах дэд хөтөлбөр болон бүрэлдэхүүн хэсгийн аль нэгийг сонгон суралцана.

Дэд хөтөлбөр (JDS Тэргүүлэх чиглэл)	Бүрэлдэхүүн хэсэг (Хөгжлийн асуудал)	Дэд бүрэлдэхүүн хэсэг
1. Макро эдийн засгийн эрүүл үйл ажиллагаа ба засаглалыг бэхжүүлэх	1-1 Төрийн санхүүгийн удирдлагын чадавхийг сайжруулах	1-1-1 Төрийн санхүүгийн удирдлага 1-1-2 Төрийн захиргаа
	1-2 Эрчимтэй зах зээлийн эдийн засгийг бүрдүүлэхэд чиглэсэн дэмжлэг	1-2-1 Санхүүгийн бодлого, хөрөнгийн зах зээлийн бодлого 1-2-2 Бизнес, эдийн засгийн эрх зүйн тогтолцоо
	2-1 Аж үйлдвэрийн бодлого ба бизнесийн удирдлага	
2. Хүрээлэн буй орчинтой зохицсон эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг хангах	2-2 Өсөлтийг хангахуйц өндөр чанартай дэд бүтцийг байгуулах	
	2-3 Хотын хүрээлэн буй орчны менежментийг сайжруулах	

Хөтөлбөрийн зорилго

Энэхүү хөтөлбөр нь Японы талаар сайн ойлголттой, мөн доорх чадваруудыг эзэмшсэн ирээдүйн удирдагчдыг бэлтгэхэд чиглэдэг;

- 1) Эзэмшсэн мэдлэг, туршлагадаа үндэслэн бодлого боловсруулах, шийдвэр гаргах чадвар
- 2) Өөрийн улс орны байр сууриас олон улсад тулгамдаж байгаа бодлогын асуудлыг шийдвэрлэхэд удирдан манлайлах чадвар
- 3) Докторын хөтөлбөрөөр олж авсан хүрээллээ ашиглан дэлхийн хэмжээнд сэтгэж, өөрийн улс орондоо эерэгээр нөлөөлөх

Чадвартай элсэгч нь эрдэм шинжилгээний ажилтны чадвараас илүү бодлогын асуудалд нөлөөлж чадах ирээдүйн удирдагч болох чадамжтай байх ёстой.


Тавигдах шаардлага

1. Монгол улсын иргэн байх
2. 2021.04.01-ний байдлаар 45 болон түүнээс доош настай байх
3. Японд магистрын зэргээ хамгаалсан байх
4. Зарчмын хувьд элсэгч нь магистрын зэрэг горилсон их сургуульдаа элсэх ёстой.
5. Магистр төгссөнөөс хойш төрийн байгууллагад үндсэн албан хаагчаар 2-оос дээш жил ажилласан байх
 - Төрийн жинхэнэ албан хаагч (Төрийн захиргаа <ТЗ> болон Төрийн тусгай <ТТ> албан хаагч)
 - Монгол банк болон Монголын хөгжлийн банкны үндсэн ажилтан
6. Гадаад орны тэтгэлгээр докторын зэрэг горилоогүй байх
7. Цэргийн албанд харъяалалгүй байх.
8. Бие махбодь, сэтгэцийн хувьд эрүүл байх

Тэтгэлгийн агуулга

JDS –н тэтгэлэгт доорх зүйлс хамрагдана.

- (1) Япон дахь их сургуулийн сургалтын төлбөр
- (2) Хоёр талын онгоцны зардал
- (3) Японд амьдрах амьжиргааны зардал (сар бүр),
- (4) Байрны мөнгө
- (5) Тээврийн зардал
- (6) Бусад зардал (Семинар, Ном сурах бичиг, Тээвэрлэлтийн зардал, Эрүүл мэндийн Даатгал, гэх мэт.)



Элсэлтийн бүртгэл

1. Өргөдлийн маягт болон элсэлтийн удирдамжийг JDS хөтөлбөрийн албан ёсны цахим хуудаснаас татаж авах боломжтой.



<http://jds-scholarship.org>

2. Өргөдлийн маягыг JICE JDS Төслийн Монгол дахь Оффист доорх хугацаанд хүлээн авна.

2020 оны 12-р сарын 4, 17:00

Сонгон шалгаруулалтын хуваарь

Өргөдлийн маягыг JICE JDS Төслийн Монгол дахь Оффист өөрийн биеэр авчирч өгнө үү.

< 2020 оны 12-р сар ~ 2021 оны 1-р сар >

JDS хөтөлбөрийн Удирдах зөвлөлийн гишүүд материалын сонгон шалгаруулалт хийнэ.

*Энэ шалгаруулалт нь тодорхой хэмжээнээс олон элсэлтийн материал ирсэн тохиолдолд хийгдэнэ.

< 2021 оны 1-р сар ~ 2-р сар >

1. JDS хөтөлбөрийн Удирдах зөвлөлийн гишүүдийн ерөнхий ярилцлагын шалгалт

Удирдах зөвлөлийн гишүүд тэнцэгчийг батлах

*Хүлээн авах их сургуулийн сонгон шалгаруулалт байгаа учир энэ шатанд "нөхцөлт тэнцэгч" болно.

< 2021 оны 4-р сар ~ 6-р сар >

2. Элсэх их сургуулийн элсэлтийн шалгалт

JDS-н оюутанд олгогдох тэтгэлэг

Доорх төлбөр болон бусад бүх элсэлттэй холбоотой зардал JDS хөтөлбөрөөс гарна:

- (1) TOEFL-ИТP шалгалт болон эрүүл мэндийн үзлэгийн төлбөр
- (2) Улаанбаатар хотод ярилцлаганд орох үеийн тодорхой хэмжээний тээврийн зардал